Алмагасын ашыгу

Аймачный Совет ОМСД.
Объединение молодых писателей
аймака

ОЖИВШИЕ КАМНИ

(Хакасские поэмы)

Перевод Б. Энэбиш

Редактор Д. Цэнджав

ДАЛАНЗАДГАД

Орчуулсан **Б. Энэбиш**
Редактор **Д. Цэнджав**
Зураг чимэглэлийг **Ж.Аварзэд**
Техник редактор **Ч. Готов**
Хянагч **Д. Янжинлхам**

Өрөлтөд 1987—9—25
Хэвлэлтэд 1987—10—5
Цаасны хэмжээ 60x90 1/64
Х.х.л. хэвлэсэн тоо 1000 хувь

«Говийн мэдээ» сонины
социалист хөдөлмөрийн
хэвлэх үйлдвэр

Михиал Кильчичаков (1919)

ДӨРВӨН МӨРТ ШҮЛГҮҮД

Унаган хүлэг чинь омголон бол
Уртын замыг эцэж цуцалгүй
туулах вий.
Учирсан хань чинь үнэнч бол
Он жил элэхийг ажиж мэдэлгүй
амьдрах вий.

х х х

Анхны хайр дурлал гэдэг
Аюултай бэрх шархлуулах бий.
Азай буурал болсон хойно ч
Аниж битүүрэлгүй шаналгах бий.

х х х

Ээж аавaа марталгүй
Ээл буянаа дээжилнэ.
Эх орноосоо хагацалгүй
Үүрд ямагт дээдлэнэ.

х х х

Харваж одсон очис
Хормын зуурт бөхөх бий.
Гэнэт дурласан сэтгэл
Хувирч дорхноо харих вий.

х х х

Эвэргүй ирэг эм хоньтой адилхан
Ургүй үг хоосон цуурайтай адилхан
Ухаалаг үгс шивнэж өчсөн ч
Үй зоны зүрх сэтгэлд хүрэх бий.

Михаил Кильчичаков (1919)

АМИЛСАН ЧУЛУУ

(Драмын найраглалын хэсгээс)

Өглөө болсон байна. Чимэд хааны цагаан гэр харагдана. Гэрийн үүдэнд үнэтэй хивс, явган ширээ, жижиг сандал байна. Бүсгүйчүүдийн зарим нь хивс цэвэрлэж, зарим нь хоол хош бэлдэнэ.

Нэг дэх бүсгүй (дуулна)
Холхи тэнгэрийн од шиг
Хоёр нүд чинь тормойж байна.
Хар нүдэн сувд эрдэнэ гээд
Хамаг олноороо чамайг магтаж байна.

Абахай
Сэрчигнэх навчис салхины аясыг заана.
Ширтэх нүд сэтгэлийн хайрыг илчилнэ.
Үнэхээр дурласан хонгор хүүтэйгээ
Уулзаж учрах тавилан заяадаг үгүй.

Хоёр дахь бүсгүй.
Үзэсгэлэн гоогоор чи минь цогцолжээ

Үеийнхээ бүсгүйчүүдээс
чи минь тодорчээ.
Үзэж харсан бүхэн үнэхээр дурлажээ
Үгүй хайрт минь чи хаана байна вэ?
Абахай
Жигүүрт шувуу адил нисье гэвч
Зориглон дүүлж чадахгүйнэ би чинь
Үнэнхүү сэтгэл минь уярч
хайлан сууна.
Үл таних ханиан гээд
хүсэж хүлээн сууна.
Сайн санаатай хүн гэдэг
Сар нар гийхтэй адил аа.
Хар санаатай хүн гэдэг
Хорт могой хатгахтай адил аа
Арчол, Албан хоёр мэдэгдэхгүй орж ирнэ.
Абахай тэднийг хараад гэнэт хашгирна.
Арчол
Хаан эзэн минь
Хатыга баатар билээ.
Хамгаалж харгалздаг нь
харин бид нар билээ.
Абахай
Үгүй тэгээд биднийг бас

хамгаалах гээ юү?

Арчол

Улаан зүртэй тулсан хойно
Өндөр хад руу шахаж
намналгүй яах вэ?
Үзэсгэлэнт бүсгүйтэй учирсан хойно
Эхнэрээ болгож авалгүй яах вэ.

Абахай

Улаан зүрээ намнаад
Идэж хэдийдээ амжаа вэ?
Үзэсгэлэнт бүсгүйтэй учраад
Болголж хэдийдээ амжаа вэ?

Арчол

Улаан зүстэй зүрээ
Улын хавцалд харлаа.
Сохтэй тарган махыг нь
Өндөр хадан дээр шарлаа.
Үзэсгэлэн гоо бүсгүйг
Эзэн хааныдаа харлаа.
Үнэн зүрхнээсээ дурлаад
Болголж авахаар ирлээ.

Абахай

Эздэрсэн олсыг тайлдаг уу чи?
Өрөөлийн сэтгэлийг танидаг уу чи?
Үг хэлээр үнэхээр айхавтар
Үнэг шиг зальтай залуу юу чи?

Үйлийн үргүй ухаантай бол
Үүнийг хараад хариулаарай чи!
Бүдүүн нарийн үзүүрийг нь
Болгосж түргэн олоорой чи!
(Арчолд зорсон хэрчим өгнө)
Албан
(Арчолд хандаж)
Алив хөвүл аятай газар очьё.
Абахай
Барьсан мод чинь нарс юм шүү!
Болгоох ухаан толгойд чинь бий юу?
Аль эсвэл алаг шаазгай адил
Арилж хэдийний алга болсон уу?
Арчол
Үзэсгэлэнт бүсгүй минь
гол дээр очоод
Оволзох ус руу нарс модоо хаяарай!
Үзүүр орой нь урьтаж хөвөх вий.
Үндэс ёзоор нь дагаж урсах вий.
Абахай
Үгүй яагаад тэр вэ?
Арчол
Үзүүр орой нь нарийн бол
Урьтаж заавал хөвөх ёстой.
Үндэс ёзоор нь бүдүүн бол
Усанд бүр живэх учиртай.

Абахай
Үнэхээр ухаалаг өчлөө чи...
Албан
(Нэг дэх бүсгүйд хандаж)
Үзэсгэлэнт бүсгүй чамтайгаа
Улиангар модны дэргэд уулзая.
Нэг дэх хүүхэн
Үгүй ээ горигүй айж байна.
Албан
Ичиж чи минь бүү эмээ
Үнэхээр би чинь яах ч үгүй.
Нэг дэх бүсгүй.
Үгүй та яасан зоримог юм бэ?
Албан
Очиж заавал уулзаарай!
Албан шумуул үргээж байгаа
дүр үзүүлэн бүсгүйн хацрыг илнэ.
Нэг дэх бүсгүй
Ямар ичдэггүй юм бэ?
Яасан зоригтой юм бэ?
Арчол явахаар одно.
Абахай
Алдар нэр чинь хэн бэ баатар минь?
Арчол
Аав ээжээс хайрласан

нэр минь Сибе.

Иртены дуу сонсогдоно. Арчол түүнийг таньж:

Хэн бэ энэ чинь?
Хэний дуу вэ энэ чинь?
Зарц бүсгүй
Сайхан санагдаж байна уу?
Абахай
Шивэгчин бүсгүй байна.
(зарц бүсгүйд хандаж)
Орилж бахирахыг нь
одоохон зогсоо
Омголон хүлгийг хазаарлаж
номхруулдаг юм.
Олхиогүй шивэгчинг ташуурдаж
хүмүүжүүлдэг юм.

Зарц бүсгүй гарч гүйнэ. Удалгүй Иртены дуу тасалдана. Ташуур тачигнан орилж хашгирах дуу сонсогдоно. Арчол арай чамай тэсэж ядна.

Албан
Болиул, болиул. Иртеныг
минь бүү тамлуул!

Арчол

Өтгөн мөчиртөө жиргэсэн шувууг
Өл бүргэд барьдаггүй юм.
Үүрийн гэгээн цолмон шиг
Үзэсгэлэн гоо чамайгаа,
Хав харанхуйг гийгүүлэх
Хонгор ялдам чамайгаа
Хамгаалж яагаад энэрсэнгүй
вэ би чинь?
Хайрлаж яагаад учирсангүй
вэ би чинь?

М. Кильчичаков

ӨМНӨГОВЬД ӨНГӨРӨӨСӨН ДОЛОО ХОНОГ

1. Говьтой золгосон нь

Алс тэртээ зургаан мянган метрээс
Асарлах тэнгэрийн
хаяа ягааран харагдав.
Аугаа уудам цөл говь
Ажилд борогшсон алга шиг дурайв.
Буянт сайхан монгол өвгөний
Буурал суусан санчиг үс шиг
Хатинги өргөст бут модод
Харах нүдэнд торойн сүглийв.
Унасан хөлөг минь газардаж
Униартан цэнхэртэх
говьтой би золгов.
Өргөн говь анирлан дүнсийж
Өвгөн бөөгийн хэнгэрэг шиг
толгой дүйрэв.
Хөлгийн хөдөлгүүр
жигдхэн нүргэлээд
Харьж мөд намдах шинжгүй.
Уул, тайгын унаган хүү би
Ой хөвч, бэл хөндийг андахгүй..
Ээрэм цэлгэр их говь

Эн хязгааргүй алдран байлаа.
Хараа алдам их говийг
Хар нүдээн бэлчээж би ажлаа.
Алсран цэлийх их говийг
Анх удаа тольдож би биширлээ.
Харваж тавьсан сум ч гэсэн
Харьж цуцан саарах бий.
Харах нүдээн сульдаан чилтэл
Халуу дүүгэсэн алсыг би ширтэв.
Асарлан унаартах говьд
Аугаа хүч хөвчлөн байна.
Цэнхэрлэн цэлийх цөлд
Цэцэглэн хөгжих тавилан байна.
Энд өргөө гэр, мал байна.
Энд өвс ногоо, ус байна.
Найман зовхист
суунаглан дуниартсан
Наран тунамал их говьд
Сүн далайд живэх мэт болов би.
Сайн байна уу, говь минь?
Энгүй говь цоонон төөнөөд
Энүүхэн хажууд зэрэглээ ирэлзээд
Нуурын ус цалгилах шиг болов.
Навчит мод найгалзах шиг болов.
Усан далай халгилаад
Урдаас тосон мэлтэлзэх шиг болов.
Ундаасаж ангасан бид

Уухын хүслэнд автсан байв.
Үгүй тэгтэл та минь
Үелзэх их долгион дундаас
Хөлөг морьтой хүн
Хүрээд наашаа ирдэг юм байна.
Уран зэрэглээ сарааД байлаа.
Унасан машин, морьтон маань
ойртоод байлаа.
Жолоо цулбууРаа хумьсаар
Зоримог морьтон дөхөөд ирлээ.
Аргамаг сайхан хүлгээсээ
Алгуур тэр буугаад ирлээ.
Учрах зочноо монгол хүн
Угтаж тийнхүү тосдог гэнэ.
Өвгөн буурал ардтай зэрэглээд
Унасан «Газик» минь зогслоо.
Их талынхаа ёсыг дээдэлж
Элэгсэг дотноор мэндлэв тэр.
Тал нутгийн чөлөөт ард
Таашааж морь шигээ машиныг
минь ажаад
Унасан хөлөг саадгүй
явна уу хэмээн
Урьдчилж биднээс болгоон асуув.
Учир утгыг тунгаан ухаараад
Өвгөн ардад хариу би талархав.
Амар мэндийг нь айлтгаж

Аргамаг хүлгийг нь лавлаад
Тал говь нутагтаа
Тавтай сайхан галгиулж
явна уу гэлээ.
Тэгтэл буурал өвгөн
Тэнхлүүн хүлгээ сайн гэж
Хариу нухацтай өчөөд
Хээтэй манан хөөргөө
Амы нь ялигүй онгойлгоод
Алгуур хүндэтгэлтэй барилаа.
Тал, өвгөнийг таашааж
би тольдоод
Та хоёрын минь хэн нь
их настай бол гэж бодлоо
Уран зэрэглээ сааран шингэрээд
Өвгөн, тал хоёр урд минь дурайв.
Атар говь чи амьдрал
шигээ мөнх юм уу?
Ард та говь шигээ бас мөнх юм уу?
Өвгөн ардын дух нь үрчийжээ.
Өргөн талын хээлэн нь зурайжээ.
Асгарах хөлсөө алчуураараа арчаад
Асарлах тэнгэр өөд
тольдож би харав.
Тэнгэр зуух шиг халан мэлтийнэ.
Тал хүхээг шиг цоонон дүнсийнэ.
Танил өвгөнөө ажиж би харлаа.

Төөнөх халуунаас хальшралгүй
бахадсан янзтай,
Баян говийн эзэн минь
Баяртай сайн сууж байгаарай.

2. Цэцгээгийн айраг.

Уулын давчуу хөндийд үймсэн
Оров дошгин унагад шиг
Чамин хээтэй мөнгөн хулд
Цалгилах айраг шуугиж байлаа.
Үзэсгэлэн гоо Цэцгээ хүүхэн
Үе дамжиж уламжилсан зангаараа
Хүндэлж дээдлэн
эелдгээр инээмсэглээд
Хултай айргаа хоёр
гардан барьлаа.
Болгоож түүнийг ажиглан харвал
Борхон царай нь өнгө ялдам ажээ.
Их говийн элчит нар чи
Үзэсгэлэнт бүсгүйнхээ
хацарт заяагаа юу?
Өгөөмөр нарны хишгийг шингээсэн
Үгалзат мөнгөн хулыг
гардаж би авахад
Шийгэх айргийн сайхан үнэр
Сэвүүн салхи шиг
гэр дүүрэн ханхийв.
Амтат айрагнаас нь балгаж

ХЭД ТОГТООТОЛ

Алд биеийг минь халуун
төөнөх шиг болов.
Сийлбэрт мөнгөн хулгай айргаа
Сэтгэл догдлон барьж уухад
Түм буман адуун сүрэг
Тургиж хуйлран үймэх шиг санагдав
Алаг зүрх минь улам лугшив уу.
Аргамаг хөлөг ороолон дэвхцэв үү.
Аньсгаа түр аньж байгаад
Аглаг хорвоог ахин тольдоход
Онгон говь өөр ертөнцөд
Омголон хөлгөөр
довтлох шиг санагдав.
Эгч дүү Гурван сайхан уул
Эрдэнэт наран тэрлэгээн
намируулаад
Элэгсэг цайлган сэтгэлийн угаас
Эрхэм зочин намайг тосон угтлаа.
Үлгэрийн баатар эр мэт
Үймж сэтгэл минь ихэд догдлов.
Үргэж боссон ногтруу шувуу
Үүлэн тэртээгээд дүүлэн одов.
Тэнгэрийн заадас тэртээд цагаараад
Тэр аяараа айраг мэт санагдлаа.
Тэргэл цагаан тэр шөнө
Тэнхээт хөлгөөр довтолгож

би давхилаа.
Айргийн бүлүүр шиг
Их долоон бурхан
Алс тэртээд гялалзан байлаа.
Хээ угалзат мөнгөн хул шиг
Хөхрөх алсад гялалзан байлаа.
Долоон сайхан од чамайгаа
Догдлох сэтгэлдээ бахдан биширлээ.
Цэвэрхэн гараараа, хултай айргаа
Цэцгээ хүүхэн сөгнөж барилаа.
Өргөө гэрт найрлан суухуй
Өр зүрх өөрийн эрхгүй уярлаа.
Туг хархан үс
Тунгалаг магнай руу нь унжсан
Сайхан монгол бүсгүй
Сэтгэл хөдлөм мишээлээ.
Аяг шимтэй айраг
Асгарч цалгитлаа оргилоо.
Адуун сүрэг цойлсон
Аагим талын бүсгүй
Хархан хөмсгөө хөдөлгөөд
Хатан зүрхийг минь уяраалаа.

3. Үйлийн тухай дууль

Дууны сайхан ая
Дуулим тал шигээ цээлхэн байлаа.
Унасан машин минь уухилж
Өргөст буттай замаар

Тоос шороо хадаагаад
Торж сааталгүй довтолгоно.
Харин тэгтэл баруун талд минь
Хатинги бут сүглийж
Хурдан хөлгийн утаа шиг
Хуйлрах тоос хөшиглөн босов.
Зээрэн сүрэг дүүлж
Зэлүүд талаа бөмбөрдөв.
Янзага үрээн дагуулж
Яахын завдалгүй арилав.
Бөжин бор туулай
Бутан дотроос булталхийж
Тэргэнд дайруулах шахаад
Тэвдэж жигтэй дүүлэв.
Туулай ингэж тааралддаг чинь
Тоогүй муу ёрдоо...
Үгүй эрхэм зочин минь
Үйлсгүй юм бодохгүй шүү.
Тэгтэл монгол андууд минь
Тэсгэлгүй их баярлаж
Нэг нь духаа атируулаад дууллаа.
Нөгөө нь алгаа ташаад өндөлзлөө.
Тэгснээ орчуулагч маань надад
Туулай тааралдах тун сайн гэлээ.
Гэтэл тэд маань гэмтсэн шувуу шиг
Гэнэт дуулахаа больчихлоо.
Үгүй энэ чинь яаж вэ гээд хартал

Үнэг сунайж байгаа харагдлаа.
Сайн нохдийнхөө царайг ажвал
Санаа нь нэг л зовсон шинжтэй
Жолооч эр маань харин
Жолоогоо огцом мушгиут
Хаазаа жигтэй нэмээд
Гайхал үнэгээ хөөлөө.
Хөдөлгүүр нь сүртэй хүржигнээд
Хүчит арслан шиг дүүллээ.
Үйл нь ирсэн үнэг
Ухаан сэхээгүй зугтав.
Үхлээс зугтсан тэр
Улаан гал шиг сунайв.
Сүүл нь шулуусч модойгоод
Сум шиг хурдан дүүлэв.
Зальт улаан үнэг
Зайлж булзах нь жигтэй.
Эрмэг «газ» машин
Эргэж тойрох нь гавшгай.
Амь өрссөн хоёр
Ач тач үзэлцэв.
Хээрийн адгуус туйлдаж
Хүчит машин дийлэв.
Урт сүүлээ чирээд
Үнэг сульдаж хэвтлээ.
Улаан хэлээ гаргаад
Уухилж нохой шиг аахиллаа.

Гэтэл харин өөдөөс
Гэнэт хүчтэй харайж
Урд дугуй мөргөөд
Ухаан алдаж уналаа.
Алгуур бид буулаа.
Авхаалж самбаат жолооч маань
Төмөр тахтай гутлаараа
Толгой дээр нь гишгээд авлаа.
Ангийн хорхойт эрсийн
Ажил гэдэг хаа мундах вэ.
Үнэг маань тэрийж хэвтлээ.
Урсах цус нь тунарч харагдлаа.
Чүүчгэр нарийн хөл нь
Чичирч хааяа татвалзлаа.
Удалгүй тэгээд тэр
Огт хөдлөхгүй нам боллоо.
Үгүй тэгсэн ч үнэг маань
Үхлээс мултрах гэж зүтгээд
Ухаан жолоогүй давхих шиг
Үргэлж надад санагдаад байлаа.
Үхэж үрэгдсэн үнэг маань
Өвсөн дотор ганцаар хоцров.
Үг дуугүй үймэрч дүнсийгээд
Өмнөх замдаа буцаж бид орлоо.
Харин тэгтэл үдэж
Хамт явсан орчуулагч маань:
Харснаа бид хөөж явдаг

Үнэг сунайж байгаа харагдлаа.
Сайн нөхдийнхөө царайг ажвал
Санаа нь нэг л зовсон шинжтэй
Жолооч эр маань харин
Жолоогоо огцом мушгиут
Хаазаа жигтэй нэмээд
Гайхал үнэгээ хөөлөө.
Хөдөлгүүр нь сүртэй хүржигнээд
Хүчит арслан шиг дүүллээ.
Үйл нь ирсэн үнэг
Ухаан сэхээгүй зугтав.
Үхлээс зугтсан тэр
Улаан гал шиг сунайв.
Сүүл нь шулуусч модойгоод
Сум шиг хурдан дүүлэв.
Зальт улаан үнэг
Зайлж булзах нь жигтэй.
Эрмэг «газ» машин
Эргэж тойрох нь гавшгай.
Амь өрссөн хоёр
Ач тач үзэлцэв.
Хээрийн адгуус туйлдаж
Хүчит машин дийлэв.
Урт сүүлээ чирээд
Үнэг сульдаж хэвтлээ.
Улаан хэлээ гаргаад
Уухилж нохой шиг аахиллаа.

Гэтэл харин өөдөөс
Гэнэт хүчтэй харайж
Урд дугуй мөргөөд
Ухаан алдаж уналаа.
Алгуур бид буулаа.
Авхаалж самбаат жолооч маань
Төмөр тахтай гутлаараа
Толгой дээр нь гишгээд авлаа.
Ангийн хорхойт эрсийн
Ажил гэдэг хаа мундах вэ.
Үнэг маань тэрийж хэвтлээ.
Урсах цус нь тунарч харагдлаа.
Чүүчгэр нарийн хөл нь
Чичирч хааяа татвалзлаа.
Удалгүй тэгээд тэр
Огт хөдлөхгүй нам боллоо.
Үгүй тэгсэн ч үнэг маань
Үхлээс мултрах гэж зүтгээд
Ухаан жолоогүй давхих шиг
Үргэлж надад санагдаад байлаа.
Үхэж үрэгдсэн үнэг маань
Өвсөн дотор ганцаар хоцров.
Үг дуугүй үймэрч дүнсийгээд
Өмнөх замдаа буцаж бид орлоо.
Харин тэгтэл үдэж
Хамт явсан олчуулагч маань:
Харснаа бид хөөж явдаг.

Халуун сэтгэлгүй хүмүүс биш
Өврөөс гарсан адгуусыг авал! гэдэг
Өвгөд дээдсийн сургаал бий.
Өртсөн дор нь унагахгүй бол
Үйлс ажил бүтдэггүй гэлцдэг.

4. Монгол бүсгүйчүүд

Сайхан монгол бүсгүйн ярилцахыг
Сонсож та ажсан уу?
Төгөл дундуур жирэлзэх
Тайгын горхины чимээ шиг
Уянга намуун аястай,
Увьдас шидийн яриатай шүү тэд.
Өвөр дээрээ бондойсон
Өхөөрдөм хонгор үрсээ
Эвийлж таалан бүүвэйлэх шиг
Эвлэг зөөлөн яриатай шүү тэд
Царайлаг монгол бүсгүйн
Цайлж дайлахыг ажсан уу та?
Увьдас шидтэй бүсгүй л
Урьсан зочноо тийнхүү дайлдаг даа.
Заєсан ширээ нь намхан ч
Зоог идээ нь арвин гээч
Амттай бүхнээ өрж өндөрлөнө.
Аяга тавгаа давхарлаж тавина.
Айлчин гийчнээ үдэхийг нь
Ажиж анзаарч харсан уу та.
Өргөө гэрээ тойруулж тэр харна.

Өгөх бэлгээ базааж тэр бэлдэнэ.
Ботгоны ноос, хурганы арьс
Боож савлаад барьж танд өгнө.
Хар нүдэн монгол бүсгүйн
Хайрлаж хэрхэн дурладгийг
мэдэх үү та?
Найр хуриманд нь очсон уу та
Нууцы нь задлахыг больёо би.

5. Говь цөлийн ухаантан

Их говийн тэмээ
Уран баримал шиг зогсоно.
Элсэн цөлөө эзэгнэээд
Үүрдийн хөшөө шиг зогсоно.
Холбоо сайхан бөх нь
Хоёр ах дүү шиг ижилсэнэ.
Хэрэв тэр бөхгүй бол
Хээр цөлд унана шүү та.
Энэ тэрийг бясалгасан
Их ухаант тэмээ
Элсэн цөлийн мэргэд шиг
Эрэгцүүлж олныг тунгаах юм.
Энэтхэг нутгийн хөвчид тэр хүрчээ.
Эрээн барстай тулж тэр учирчээ.
Булиңгарт нүдтэй тэр
Болгоож бүхнийг цэгнэх юм.
Түүх шашдир туурвигсад
Тэмээг бас анзаарвал таарна.

Их говийн ухаант тэр
Өрөөл бусдыг тоодоггүй гэнэ.
Гэнэн хүн шиг тэр
Гай зовлонд өртсөн юм болов уу?
Үр удамдаа тэр
Өгүүлж захидаг өчигтэй гэнэ.
Эрт урьдын цагт
Их сайхан эвэртэй байж гэнэ.
Үнэн худлыг бүү мэд
Үлгэр домог хүүрнэдэг гэнэ.
Уран марал буга
Эвэргүй тоймог байж гэнэ.
Олон адгуус хураад
Онцгой гойд найрлаж гэнэ.
Тэгэхэд марал буга
Тэр бүхэнд гайхуулах гэж
Буурын сайхан эврийг
Булга татаад авч гэнэ.
Буцааж өгнө хэмээн амалсан ч
Булзаж зугтаад болдоггүй гэнэ.
Эвэргүй болохоор түүнээс
Ингэ нь бүр буруулж гэнэ.
Тэгээд тун хавьтдаггүй гэнэ.
Тэрсэлж жигтэй уурладаг гэнэ.
Эвэр сүргүй ханиасаа
Ингэ нь үргэлж буруулдаг гэнэ.
Тэр цагаас хойш

Тэмээ ямагт бодлогоширдог гэнэ.
Атар сайхан говьд
Атан тэмээ гунганав.
Эзнээ тэр дуудав болтой.
Эвэрт бугыг эрэх болтой.
Эзэн тэмээчин эр
Эхнэртэйгээ салах ёс гүйцэтгэв.
Энхрий сайхан хань нь
Эрдэнийн дусал нулимс унагав.

6. Говиос буцсан сэтгэлийн өчил

Жаргах нарны туяа
Цөлийн хээлэнд тусав.
Хатинги хахир цөл чи
Харж ажихад хатуу ч
Ээл буянаа заяасан
Ээжийн минь гар шиг зөөлөн юм.
Эгшиг сайхан дуу
Увьдис яруу уянгатай юм.
Өл бүргэд тэнгэрт чинь дүүлнэ.
Омголон хөлөг цээжин дээр
чинь дэлдэнэ.
Шингэх нарны туяа
Шунхан улаан байлаа.
Сэлүүн цэнхэр говьд
Сэтгэл зүрх минь хоцорлоо.
Ээлт сайхан тал чи

Энх мөнхийг заяалаа.
Эрдэнийн улаан чулуунд чинь
Элэг зүрхнээсээ биширлээ.
Тэнэгэр говийн чимэг
Тэмээн сүрэг бэлчсэн,
Улаан үнэг эрсдэж
Элсэн дээр атиралдсан
Хатинги бутат говийн
Халуун судас лугшиж байна.
Шингэх нарны туяа
Шунхан өнгөөр улалзаад
Өнгө, гэрлийн орчилд
Өмнөх зам минь дурайв.
Үзэсгэлэнт ногоон тайга минь
Элсэн говийг магтав гэж
бүү гомдоорой.
Үзэж бахадсан бүхнээ
Өгүүлж магтахын хүслээр
жигүүрлэв би.
Элэг зүрхний хэлтэрхий гэмээр
Эрдэнийн улаан чулуутай
Уудам говьд биширсэн намайгаа
Уучилж өршөөгээрэй уул минь!
Үзэсгэлэн гоо монгол бүсгүй
Өргөө гэрийнхээ хаяанд зогсоод
Сайн явахын ерөөл дэвшүүлж
Сацал сүүгээ дээдлэн өргөлөө.

Саран гоо монгол бүсгүйн
Сацал сүүгээ өргөхийг хараад
Шөнө дөл тэртээд гийсэн
Долоон бурхнаа саналаа.
Сөгнөж байж шимтэн тогтоосон
Айраг цагаагаа дурслаа.
Их говь минь баяртай,
Эргэж уулзталаа баяртай!

Василий Кобяков (1906—1937)

МАЛЧИН ТОРКА

Аагим халуун, жин хүйтэнд
Асгат ууландаа бэдэж тэр явжээ.
Барааны тэртээх Саяныхаа ууланд
Баяд ноёдын сүргийг
хариулж тэр явжээ.
Үдшийн бүрий татаж
харанхуй болоход
Үйлт шуурга исгэчин
ороолгодог байжээ.
Идэх хоолгүй гэдэс нь
тасрах шахаад
Өлөн чоно адил улих нь
халаг үгүй явжээ.
Уранхай нэхий дээл халцарч
хэдийнээ салбараад
Үй түмэн сүрэг адгуулагч
хөлдөж үхэхэд хүрчээ.

ГАРЧИГ

1. Хоньчны бодол 3
2. Өчигдөр, өнөөдөр хоёр . . 5
3. Хайжийн дуу 8
4. Ирээдүй 10
5. Дөрвөн мөрт шүлгүүд . . 12
6. Амилсан чулуу . . . 14
9. Төрөлх нутаг 40
7. Өмнөговьд өнгөрөөсөн долоо хоног 22
8. Малчин Торка 37
10. Шинэсний үр 42
11. Цагаан Июс 43
12. Амралтын цэцэрлэг . . 46
13. Тайгад одсон зам . . . 47
14. Талд ирсэн анхны галт тэрэг 49
15. Чатхан 50
16. Тракторчны дуу . . . 52
17. Малчин 54

Үнэ 2 төг 50 мөн